



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 1/10

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 14/04 дүгээр тогтоолоор батлагдсан төсөл арга хэмжээнд тусгагдсан Нийтийн үйлчилгээний байгууллагуудын ажилчдын ажлын байрны тохижилтын ажлын даалгавар бэлэн болсон тул ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Равданпүрэв (Төрийн байгууллагын төлөөлөл)

Б.Пүрэвсүрэн (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

М.Ичинхорлоо (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Э.Цолмон (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Даваасамбуу)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Цолмон)-т үүрэг болгосугай.

ДАРГА

б. Сандагсүрэн

Б.САНДАГСҮРЭН

8400003 0225

Tush A/40 Kh